



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 337

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн 2025 оны “Зөвшөөрөл олгох тухай” 63 дугаар тогтоолын 1, 2, 5, 6, 11, 13, 15, 18, 20 дугаар хавсралтад дараах нэмэлт, өөрчлөлт оруулахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нар тус тус зөвшөөрсүгэй.

1.1.2025 оны 63 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтын “Зорилт” хэсгийн “2.Малын генетик нөөцийн...гүйцэтгэлийг тайлагнах” гэсний дараа “3.Мал сүргийн зохистой бүтэц, харьцааг малын төрөл, ашиг шимийн чиглэл, үүлдрийн онцлогийг харгалзан тогтоох, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлийг тайлагнах;” гэж, “Албан тушаалын хэрэгжүүлэх чиг үүрэг” хэсгийн “2 дугаар зорилтын хүрээнд” хамаарах хэсгийн дараа “3 дугаар зорилтын хүрээнд” гэж, “1.Бүс нутгийн түвшинд хамгаалах, цөм сүрэг бүрдүүлэх чиглэлээр шийдвэрийн төсөл боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах; 2.Үржлийн малд хянан магадалгаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах; 3.Хээлтүүлэгчийг сонгох, хээлтүүлгийн тохироог тооцох, малын төрөл, тоо, сүргийн бүтцийн зохистой харьцааг баримтлах хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах; 4.Нийлүүлгийн бус улиралд хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх, бэлчээрийн малын чанарыг сайжруулах хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;” гэсэн хамаарах хэсэг тус тус нэмсүгэй.

1.2.2025 оны 63 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтын “Мэргэжил” хэсэгт “хөдөө аж ахуй /081/”, “хүнс, боловсруулалт /0721/”, “материал боловсруулалт /0722/”, “хөнгөн үйлдвэрийн технологи /0723/”, “биологи ба холбогдох шинжлэх ухаан /051/”, “хүрээлэн буй орчныг хамгаалах технологи /0712/” гэж, тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтын “Мэргэжил” хэсэгт “хүнсний биотехнологи /078802/”, “хүнсний микробиологи /078803/” гэж, 13 дугаар хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтын “Мэргэжил” хэсэгт “өрөмдлөгийн инженерчлэл /072405/” гэж, тогтоолын 6,15,20 дугаар хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтын “Мэргэжил” хэсэгт “менежмент ба удирдахуй /0413/” гэж тус тус нэмсүгэй.

1.3.2025 оны 63 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтын “Зорилт” хэсгийн дугаарлалтын “3” гэснийг “4” гэж, “Албан тушаалын хэрэгжүүлэх чиг үүрэг” хэсгийн “3 дугаар зорилтын хүрээнд” гэснийг “4 дүгээр зорилтын хүрээнд” гэж тус тус өөрчилсүгэй.

1525010939

1.4.2025 оны 63 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтын "Мэргэжил" хэсгийн "мал эмнэлэг /0841/" гэснийг, 18 дугаар хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтын "Албан тушаалын хэрэгжүүлэх чиг үүрэг" хэсгийн "3 дугаар зорилтын хүрээнд" хамаарах хэсгийн "4.Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг цаг үеийн нөхцөл байдалд нийцсэн мэдээ, мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, тайлагнах;" гэснийг тус тус хассугай.

2.Нэмэлт өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг томилох эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, мөрдүүлэх, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж ажиллахад нь хяналт тавьж, мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны дэргэдэх Салбар зөвлөлийн дарга (Т.Жамбалцэрэн)-д даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу томилогдон ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хангаж, эрх зүйн байдлыг дордуулахгүй байх арга хэмжээ авахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарт зөвлөсүгэй.

4.Хянаж, зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (В.Жавзан)-д даалгасугай.

ДАРГА



Л.ЦЭДЭВСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Мал аж ахуйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Үйлдвэр, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Газар тариалангийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Хяналтын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Захиргаа, удирдлагын хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Хүний нөөц, сургалт, сурталчилгаа, төлөвлөгөө, тайлан хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Мал аж ахуйн хэлтсийн Малын удам зүйн үнэлгээ, үржил, селекц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Малын удам зүйн үнэлгээ, үржил, селекц хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Малын генетик нөөцийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Малын генетик нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Мал аж ахуйн үйлдвэрлэл, эрхлэгч, эрсдэлийн удирдлага хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Малын бэлчээрийн менежментийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 16 дугаар, Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар, Хөнгөн болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 18 дугаар, Газар тариалангийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 19 дүгээр, Хүнсний үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 20 дугаар, Газар тариалангийн хэлтсийн Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, хүлэмжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 21 дүгээр, Газар тариалангийн техник, технологийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 22 дугаар, Хяналтын хэлтсийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын

1525010197

байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 23 дугаар, Таримал ургамлын үр, сортын хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 24 дүгээр, Ургамал хамгааллын хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 25 дугаар, Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 26 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

2.Батлах зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг томилох эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, мөрдүүлэх, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны дэргэдэх Салбар зөвлөлийн дарга (Д.Жамбалцэрэн)-д даалгасугай.

3.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (В.Жавзан)-д даалгасугай.

4.Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу томилогдон ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хангаж, эрх зүйн байдлыг дордуулахгүй байх арга хэмжээ авахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарт зөвлөсүгэй.

5.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 64, 118, 129, 140, 152, 190, 200, 213, 230, 239, 249, 259, 268, 277, 286, 296, 328, 341, 351 дүгээр, 2023 оны "Зөвшөөрөл олгох тухай" 30 дугаар, 2024 оны "Зөвшөөрөл олгох тухай" 98 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.ЦЭДЭВСҮРЭН